



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 347  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН  
ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ ТАНАА**

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудитын MNS 6817 – 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим Төрийн аудит MNS 6817 – 8 : 2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.


**Дүгнэлт**

Ардчилсан намын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

006920524

Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / 11. хуудас/-ийг хавсаргав.  
Хувийг: Булган аймгийн Сонгуулийн хороонд  
Хавсралт 11. хуудастай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



БУЛГАН АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2020 ОНЫ АЙМГИЙН  
ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ШИНЭ БУЛГАН” МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР



**АЖИЛТАЙ ОРЛОГОТой – БУЛГАНЧУУД**

*Хөдөө аж ахуйд суурилсан үйлдвэржилт, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.*

**1. Үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр**

**1.1 Үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр**

Орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэн, олон тулгуурт эдийн засгийг бий болгож, аймгийнхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

- ✓ “Нэг суурин - Нэг үйлдвэрлэл” хөдөлгөөнийг сум тус бүрийн онцлог уламжлалт аргад тулгуурласан эцсийн бренд бүтээгдэхүүнийг боловсруулан зах зээлд нэвтрүүлнэ.
- ✓ Аймгийн ИТХ-аас тогтоосон үйлдвэржилтийн бүсүүдэд, орон нутгийн ААН байгууллагуудад газар олголтыг үе шаттай шийдвэрлэж зах зээлд өрсөлдөх чадвартай дэвшилтэт технологи бүхий үйлдвэрүүдийг хөгжүүлнэ.
- ✓ Сумдын газар зүйн онцлог, байгалийн нөөц, дэд бүтцийн нөхцөл зэрэгт нийцүүлэн арьс шир, ноос ноолуур, өлөн гэдэс, сүү цагаан идээ, жимс жимсгэнэ, хүнсний ногоо зэрэг боловсруулах чиглэлийн жижиг дунд үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлнэ.
- ✓ Булган сумын үйлдвэрлэлийн бүсэд жижиг дунд үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлж, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэнэ.
- ✓ Боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийг нэмэгдүүлж, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн сүлжээг боловсронгуй болгож, боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлнэ.
- ✓ Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн парк байгуулна.
- ✓ Булган, Сэлэнгэ, Хутаг-Өндөр, Орхон зэрэг сумдын гурилын үйлдвэрүүдийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж, Бүрэгхангай, Тэшиг, Баян-Агт сумдад гурилын жижиг үйлдвэр байгуулах замаар аймгийн гурилын дотоодын хэрэгцээг хангана.
- ✓ Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Орхон зэрэг сумдад элит болон нутагшсан монгол сортын үрийн нөөц бүрдүүлнэ.
- ✓ Экологийн цэвэр бүтээгдэхүүн, орон нутагт үйлдвэрлэсэн органик хүнсний аюулгүй сүлжээг өргөжүүлнэ.
- ✓ Хялганат тосгоны шахмал түлшний үйлдвэрлэлийг жигдрүүлж, Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатар хотуудад бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлнэ.

- ✓ Өндөр технологи нутагшуулах төв байгуулан аймагт түгээмэл тархацтай барилгын материалын түүхий эдийг боловсруулах, цемент, барилгын бетон хийц, тоосго, эрдэс будаг зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- ✓ Аймгийн бодлогын бичиг баримтууд болон уул уурхайн ашиглалт, экосистемийн өнөөгийн нөхцөл, цаашдын хандлага, бэлчээр ашиглалт, хүн амын суурьшилтай уялдуулан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.
- ✓ Булган, Хутаг-Өндөр, Дашинчилэн, Сэлэнгэ зэрэг сумдад махны чиглэлийн загвар аж ахуй байгуулж мал бордох, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор болгон өргөжүүлнэ.
- ✓ Булган суманд барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркыг Бугат сумын Их залуу уулын барилгын чулууны ордыг олборлохтой уялдуулан зохион байгуулна.

## 1.2 Худалдаа, үйлчилгээний чиглэлээр


**Аймгийн худалдаа үйлчилгээний салбарыг тэлэх бодлого баримтлан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.**

- ✓ Сумдад ахуй үйлчилгээний төвийг үргэлжлүүлэн байгуулж ашиглалтанд оруулна.
- ✓ Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулахыг дэмжин ажиллана.
- ✓ Худалдаа, үйлчилгээний салбарт өндөр бүтээмжтэй техник технологийг тууштай нэвтрүүлнэ.
- ✓ Орон нутгийн худалдаа үйлчилгээний газруудын чанар стандарт, хангалтыг дээшлүүлж хүн амыг олон нэр төрөл бүхий чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах, худалдааны мэдээллийг төрөлжүүлэн зохион байгуулж бодлого шийдвэрт ашиглах худалдааны зохистой хяналт хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Худалдаа, үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн түвшинг дээшлүүлж, үйлчилгээний чанар стандарт, бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулна.
- ✓ Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг тэдгээрийн эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудаар дамжуулан аймгийн бодлого шийдвэрт тусгана.
- ✓ Худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж буй аж ахуй нэгжүүдийг, зээл, хөрөнгө оруулалтын оновчтой бодлогоор дэмжинэ.

## 2. Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр

### 2.1 Газрын харилцаа барилга, хот байгуулалтын чиглэлээр

**Хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт газрын харилцааг боловсронгуй болгоно.**


- 
- ✓ Булган сумын төвд шинээр төлөвлөсөн Цэнгэлдэх, Онгоцны буудлын суурьшлын бүсүүдийн дэд бүтэц бүхий инженерийн хангамжийг үе шаттай шийдвэрлэнэ.
  - ✓ Булган сумын 6 дугаар багт залуус хороолол, 2, 3 дугаар багийн А, В хорооллыг инженерийн шугамд үе шаттай холбоно.
  - ✓ Булган сумын төвийн газар доорх инженерийн шугам сүлжээний шинэчлэгдээгүй үлдсэн 10 хувь бүхий шугамын ажлыг үргэлжлүүлэн гүйцээнэ.
  - ✓ "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, сумдыг төвлөрсөн дулаан цэвэр бохир, цэвэр усны нэгдсэн системийг өргөжлүүлнэ.
  - ✓ Дулааны станцын үйл ажиллагааг сайжруулан, хуучирсан инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн ажлыг шат дараатайгаар шийдвэрлэж, хуучны байруудыг хэрэгцээний халуун устай холбоно.
  - ✓ Булган сумын 4 дүгээр баг Зүүн түрүүнд бие даасан эх үүсвэр бүхий дэд бүтцийг зураг төслийн дагуу шийдвэрлэнэ.
  - ✓ Булган суманд 500 айлын орон сууцны цогцолбор хорооллыг бүрэн барьж дуусган ашиглалтанд оруулна.
  - ✓ Булган сум болон дэд бүтэц шийдэгдсэн сумдад түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж төрийн албан хаагчид, ахмад, шинээр гэр бүл болж буй зэрэг зорилтод бүлгийн иргэдийн хамрагдах нөхцлийг бий болгоно.
  - ✓ Сумдад шинэ суурьшлын бүсийг бий болгон инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцыг шугам сүлжээнд холбож, нөхцөлийг сайжруулах замаар ипотекийн зээлийн шаардлага хангасан 10-аас доошгүй орон сууцнуудыг сум бүрд барих
  - ✓ Сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд орон сууцны зориулалтаар тусгагдсан газруудад дэд бүтцийг байгуулах, орон сууц барих чиглэлээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
  - ✓ Булган сумын сургууль, цэцэрлэг цогцолбор барилгын тоог нэмэгдүүлнэ.
  - ✓ Аймаг, орон нутгийг холбосон авто замыг түшиглэсэн түр амрах цэг бүхий амралтын цогцолбор газруудыг шинээр байгуулна.
  - ✓ Аймгийн төв талбайн тохижилтыг үргэлжлүүлэн сайжруулж хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэн төв гудамжинд гоёлын ургамлаар бүрэн тарималжуулж нэрэмжит гудамж, цэцэрлэгийг бий болгоно.
  - ✓ Хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн ажиллаж хөдөлмөрлөх тавтай орчинг бүрдүүлнэ.
  - ✓ "Сайн хашаа", "Жорлонгоо өөрчилье" зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
  - ✓ "Гудамж төсөл" хэрэгжүүлнэ.

## 2.2 Тээвэр, автозамын чиглэлээр

**Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээвэр, автозамын чанар хүртээмжийг сайжруулна.**

- ✓ Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

- ✓ Булган суманд зорчигч тээврийн автовокзалын барилгыг барина.
- ✓ Аймгийн автозамын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулж мөрдүүлнэ.
- ✓ Аймгийн төвийн авто зам, замын байгууламжийг сайжруулж, зам уулзварын өргөтгөл шинэчлэлийн ажлыг хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлнэ.
- ✓ Орхон аймгаас – Булган аймгийн Хангал-Хялганат тосгон хүртэлх авто замыг барьж ашиглалтанд оруулна.
- ✓ Тэшиг сум, Бага илэнхийн боомт хүртэлх босоо тэнхлэгийн замын зураг боловсруулан үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- ✓ Орон нутагт байгаа улсын болон орон нутгийн чанартай төмөр бетон гүүрнүүдэд их засвар хийх ажлыг зохион байгуулах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.
- ✓ Тээврийн ложистикийн сүлжээ байгуулна.
- ✓ Босоо тэнхлэгийн Булган-Гурванбулаг чиглэлийг авто замыг ашиглалтанд оруулна.



### 2.3 Эдийн засгийн чиглэлээр

**Хөдөө аж ахуй, аялал жуулчлалд тулгуурласан оновчтой бодлогыг хэрэгжүүлэн эдийн засгийг тогтвортой хөгжүүлнэ.**

- ✓ “Булган Эдийн засгийн форум” “Хөрөнгө оруулагчдын чуулган”-ыг үе шаттайгаар зохион байгуулж дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татна.
- ✓ Булган аймгийн Тэшиг суманд бага Илэнхийн боомтод тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгох техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.
- ✓ Булган аймгийн Орхон суманд ОУ-ын нисэх онгоцны буудлыг шинээр байгуулах, түүнийг дагаж үүсэх шинэ суурьшлын бүс үүсгэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- ✓ Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон төв болгоно.

### 2.4 Эрчим хүчний чиглэлээр

**Эрчим хүчний хэрэгцээг тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж нийт хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлнэ.**

- ✓ Эрчим хүчний хэрэгцээг тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж нийт хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлж, баг сумын төв, хөдөөгийн малчин айл өрхийн гэрэлтүүлэг болон бусад хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангана.
- ✓ Нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг барилга байгууламжинд хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглана.
- ✓ Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллахыг дэмжинэ.

## 2.5 Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр

Нийт хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамааран ижил хурдны үнэ тарифыг мөрдөж, сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалыг нэмэгдүүлнэ.


- ✓ Аймаг, сумын төвүүд болон томоохон суурин газрууд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернэт холбогдох WIFI орчинг нэмэгдүүлнэ.
- ✓ Баяннуур-Дашинчилэн-Гурванбулаг-Рашаант-Хишиг-Өндөр сумдад төрийн байгууллагуудыг шилэн кабельд холбох ажлыг үргэлжүүлж үе шаттайгаар шийдвэрлэнэ.
- ✓ Интернэтийн хурдыг сайжруулж, үнийг багасгаж хот хөдөөгийн эцсийн хэрэглэгчийг адил үнээр хамрагдахыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Булган сумын төвийн хэсэгт гэр хорооллуудыг хамруулан 1 км-ын радиустай утасгүй интернэттэй болгоно.
- ✓ Булган сумын төвд IPTV /Univision, Skymedia/ зэрэг үйлчилгээг өргөжүүлнэ.
- ✓ Булган аймгийн нутаг дэвсгэр дээр байгаа аялал жуучлалын баазуудыг интернэтэд холбогдох нөхцлийг бүрдүүлж жуулчдын урсгалын нэмэгдүүлнэ.
- ✓ Хөдөөгийн алслагдсан багуудын үүрэн операторуудын сүлжээг сайжруулах, 3G сүлжээтэй болгох

## 3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны хэрэгцээг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, ажлын байрыг бий болгоход чиглэсэн боловсрол сургалтын үйл ажиллагааг дэмжиж албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг сайжруулан "Ажлын байр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- ✓ Гадаадын улс орнуудад "дадлагажигч ажилтан бэлтгэх" хөтөлбөр хэрэгжүүнэ.
- ✓ Зохион байгуулалттай хөдөлмөр зуучийн үйлчилгээг дэмжиж, цалин, хөдөлмөрийн хөлсний уян хатан бодлого хэрэгжүүлж, цагийн ажлын байр, цагийн хөлсний системд шилжинэ.
- ✓ Амьжиргааны түвшин доогуур иргэд болон бага малтай залуу малчин өрхийг дэмжиж малжуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- ✓ Мах, сүү, гурил, хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого барьж орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжиж, дотоод зах зээлээ хамгаална.
- ✓ Байгаль орчныг хамгаалах, нийтийн эзэмшлийн талбайг засах, тохижуулах зэрэг нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр хамруулна.
- ✓ "Булганд үйлдвэрлэв" төвийг өргөжүүлж, сумдын Брэнд болон орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг өргөжүүлнэ.
- ✓ Хөдөлмөр зуучлалын нэгдсэн сүлжээг нэвтрүүлэх, сум бүрт цахим биржтэй болно.

- ✓ Төр, ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн 3 талт хамтын ажиллагааг өргөжүүлж сумдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодыг чадавхжуулна.
- ✓ Оюутан залуучуудын холбоод болон ТББ-тай хамтарч залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ✓ Сум хөгжүүлэх сангийн үр өгөөжийг дээшлүүлж, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- ✓ Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, барилгын ханын материалын үйлдвэрлэлийг түлхүү дэмжинэ.



#### 4. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр

**Нийт мал сүргийн бүтцийг зохистой болгон, дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажсан өвчингүй статустай аймаг болгон, мал малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргана.**

- ✓ "Шинэ хөдөө" төслийг хэрэгжүүлнэ.
- ✓ "Чинээлэг малчин" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ✓ Аймгийн төвд мал эмнэлгийн лаборатори, сумдад мал үржлийн нэгж, хувийн мал эмнэлгийн үйлчилгээг дэмжинэ.
- ✓ Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг үндсэн сайжруулагчаар ашиглаж, ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- ✓ Хонин сүргийн үндсэн сайжруулагчаар Баяд үүлдэр, Дархад, Хотонт омгийг ашиглана.
- ✓ Нарийн ноост Хангай үүлдрийн хонины генофондыг хамгаалж, тоо толгойг өсгөнө.
- ✓ Ямаан сүргийн үндсэн сайжруулагчаар Эрчмийн хар, Баяндэлгэрийн улаан омгийг ашиглана.
- ✓ Малчид болон боловсруулах үйлдвэр хоорондын шууд харилцааг дэмжиж, МАА-н түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой сүлжээг орон нутагт бий болгоно.
- ✓ Өвөлжөө хаваржааны бэлчээрийг, худаг уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд урт хугацааны гэрээгээр эзэмшүүлнэ.
- ✓ ХАА-н биржийн арилжааг идэвхижүүлнэ.
- ✓ Булган суманд газар нь олгогдож эхлэсэн ХАА-н үйлдвэрлэлийн бүсийг үйлдвэрлэл технологийн парк болгон хөгжүүлнэ.
- ✓ Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникын болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэн, хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж элэгдэл, эвдрэлийг сааруулна.
- ✓ Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал, Орхон, Сэлэнгэ, Бугат сумдад овъёос, Хангал, Хутаг-Өндөр, Баян-Агт сумдад арвай, Хангал, Сэлэнгэ, Орхон сумдад хөх тариа, бог будаа тариалалтыг нэмэгдүүлнэ.

- ✓ Үр тарианы үр үржүүлгийн аж ахуйг Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Орхон суманд байгуулан ганд тэсвэртэй, бүс нутгийн нөхцөлд тохирсон Булган аймгийн нэрийн үр сортыг бий болгож хэрэгцээг хангана.
- ✓ Хөдөө аж ахуйд давхар даатгал, санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

### **АМГАЛАН ТАЙВАН - БУЛГАНЧУУД**

6317144798  
ГЮА0048 3190269

**Иргэн аж ахуйн нэгжийг болзошгүй гамшиг, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах чадамжийг дээшлүүлэн амар амгалан ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.**

#### **1.1 Батлан хамгаалах чиглэлээр**

**Иргэн, цэргийн харилцааг бэхжүүлэх бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулж, аймгийн дайчилгааны хэрэгсэл нөхцлийг бүрдүүлэн, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий уялдаа холбоо хамтын ажиллагааг бэхжүүлнэ.**

- ✓ Батлан хамгаалах туслах нийгэмлэг болон бусад байгууллагуудтай хамтран хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгоно.

#### **1.2 Нийгмийн хэв журмын чиглэлээр**


**Нийгмийн хэв журам сахиулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн иргэнд ээлтэй эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ.**

- ✓ Шинэ суурьшлийн бүсүүдэд камержуулах, төв суурин газрын гудамж талбай, үйлчилгээний газруудын гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээг сайжруулна.
- ✓ “Архигүй Булган” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж архи тамхины зөв зохистой хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.
- ✓ Цагдаагийн албан хаагчдын ур чадвар ажиллах нөхцөл, техник хэрэгслийн чанар хүртээмжийг сайжруулах замаар гэмт хэргийн гаралтыг багасгана.
- ✓ Малын хулгай, орон байрны хулгай, хориотой ан агнуур, хулгайн мод зэрэгтэй тэмцэнэ.
- ✓ Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг дэмжин ажиллана.

#### **1.3 Онцгой байдлын чиглэлээр**

**Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшигийг тандан судлах, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээнд болон орон нутгийн түвшинд гамшигийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах олон нийтэд тулгуурласан менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, гамшигтай тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ.**

- ✓ Болзошгүй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сайн дурын бүлэг, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжинэ.
- ✓ Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулж гамшгаас хамгаалах болон удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага хийх
- ✓ Онцгой байдлын газрын шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулж парк шинэчлэлт, гар багаж зэвсэглэмжийг нэмэгдүүлэх



#### 1.4 Хүн ам зүйн бодлого

**Хүнсний аюулгүй байдлыг хангах, аймгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, аймгийн иргэдийн тоог тогтмол нэмэгдүүлж хүн амыг амьдрах ая тухтай орчинг бүрдүүлнэ.**


- ✓ Хүнсний аюулгүй байдлыг цогцоор нь хангах аймгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж сургалтын давтамж, хүртээмж, үр дүнг сайжруулна.
- ✓ Хүн амыг амьдрах аятай тухтай орчныг бүрдүүлэн нийгмийн халамж үйлчилгээг сайжруулан хүн амыг тогтвортой өсгөнө.
- ✓ Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж баталгааг хангана.
- ✓ Хүнийг хөгжүүлэх, хүний нөөцийг бүрэн дүүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэнэ.
- ✓ Нийгмийн халамжийн зорилтод бүлгүүдэд чиглүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, ахмад настан, эмэгтэйчүүдэд үзүүлдэг тусламж, хөнгөлөлтийг сайжруулах замаар дэмжлэг үзүүлэн ажиллана.
- ✓ Жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана.
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг идэвхжүүлэх, харилцаа хандлагыг нь хөгжүүлэх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх, сэргээн засах төв, хөгжлийн төвүүдийг байгуулж, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлийн төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлж дэмжинэ.
- ✓ “Ахмадын хөгжлийн төв”, ахмадын амралтын газрын материаллаг баазыг сайжруулан ахмадуудад аятай тухтай амрах нөхцлийг сайжруулна.
- ✓ Булган аймгийн хүүхдийн “Жаргалант зуслан”-г ерөнхий төлөвлөгөөний дагуу үе шаттайгаар барьж ашиглалтанд оруулна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоог суурин хүн амын 90 хувьд хүргэнэ.
- ✓ Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн зорилтод бүлгүүдэд хандсан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дэмжлэг тусалцааг нэмэгдүүлнэ.

#### ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ - БУЛГАНЧУУД

**Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг боловсрол, соёлын түвшинд төлөвшүүлнэ.**


##### 1.1 Бүх шатны боловсролын чиглэлээр

**Боловсролын байгууллагын төрөл, чанар хүртээмжийг сайжруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.**



- ✓ "Шатар" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд орон нутгийн онцлогийг харгалзан үйл ажиллагааг явуулах
- ✓ Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулиудыг 2-оос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, хүүхэд залуучуудын нутаг орноороо бахархах үзэл, хандлагыг төлөвшүүлнэ.
- ✓ Мэргэжлийн боловсрол сургалтын багшлах боловсон хүчнийг чадавхижуулж, техникийн баазыг хөгжүүлж суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.
- ✓ "Шинэ багш" хөтөлбөр хэрэгжүүлж дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна.
- ✓ "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгоно.
- ✓ Хүүхдийг цахим гэмт халдлагаас хамгаална.
- ✓ Хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлнэ.
- ✓ Насан туршын боловсролын тогтолцоог боловсронгуй болгож бүх шатны боловсролын чанар хүртээмжийг сайжруулна.
- ✓ Өдөөй аон и+еэй нодоооёь, цэцэрлэгийя аеиāā, нойāūī о°āā āāēāóóēāī āāēēóóēāōāā āāō āāēūī āūīāēūā āāēēēē.
- ✓ Булган хангайн МСҮТ, ХАА-н МСҮТ-ийг түшиглэн коллеж, их дээд сургууль байгуулах чиглэлээр холбогдох яам, бусад байгууллагатай хамтран ажиллана.
- ✓ Булган аймгийн төвд Төрөлжсөн сургалттай ахлах сургууль байгуулна.
- ✓ Áāāā īāōūā īōīī нōōōīū о°о°ēā°ōō ðāīðōóēāō, īōīī íōōāēēī о°ñā°ñ āāāō īāōō çīðēóēāī īōīī нōōō āāðēōāā о°ð°īā° ðōāēāðēāō, ðōāēāðāā īōīī нōōō āāðēōūā āūīāēēēē āāāā ðāāōūē, óðò ðōāāōāāīū çūūēд хамруулна
- ✓ Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хөрвөх чадвартай болгон хөгжүүлж, сургалтын техник хэрэгсэл лабораторийн хүрээлцээг 100% хангаж, олимпиад, уралдаан тэмцээний чанар хүртээмж оролцоог нэмэгдүүлнэ.
- ✓ Хүүхдийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн "Хүүхдийн хөгжил - Бидний ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- ✓ Сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны техник тоног төхөөрөмж барилгын урсгал засвар, их засваруудыг шат дараатайгаар хийж суралцах нөхцөл байдлыг сайжруулан ажиллана.
- ✓ Боловсрол соёлын салбарын гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- ✓ Багшлах боловсон хүчнийг чадавхжуулах, сонгон шалгаруулах, сэлгэн ажиллах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- ✓ Концессын жагсаалтаар сумдад сургууль, цэцэрлэгийн цогцолборыг барьж ашиглалтанд оруулна.



## 1.2 Соёлын чиглэлээр

Соёлын өв, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар стандартыг сайжруулах замаар аймгийн нэрийг дотоод, гадаадад иргэдэд сурталчилна.

- ✓ Уламжлалт өв соёлоо төрийн бодлогоор дэмжин, боловсролын хөтөлбөрт тусгаж, Монгол хүнийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарна.
- ✓ Контент бизнесийг дэмжих замаар Монгол үндэстний өв соёлыг сурталчилна.
- ✓ Соёл урлагийн байгууллагуудын /номын сан, музей, соёлын төв, театр/ бүтэц зохион байгуулалтыг сайжруулж, соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжтэй тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Иргэдийн сонирхолд нийцсэн эвент арга хэмжээг зохион байгуулж соёлын чиглэлээр дотоод гадаадын харилцааг хөгжүүлнэ.
- ✓ Соёл урлагийг хөгжүүлэх түгээн дэлгэрүүлэх, соёлын үйлчилгээг шинэ шатанд гаргах зорилгоор аймгийн соёл урлагын бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.
- ✓ ОХУ-ын Буриад, БНХАУ-ын ӨМӨЗОрны музейнүүдтэй хамтран ажиллана.
- ✓ Соёлын биет бус “Ардын Урлаг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Соёлын биет өвийг хамгаалах, хадгалах, сурталчилан таниулах замаар дотоодын болон гадаадын жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ
- ✓ Орчин үеийн урлагийн төрлүүдийг хөгжлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.


## ЭРҮҮЛ ЧИЙРЭГ – БУЛГАНЧУУД

*Зонхилон тохиолдох халдварт бус ба, халдварт өвчин, нөхөн үржихүйн оношилгоо, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн нийтийн биеийн тамираар хичээллэх нөхцлийг бүрдүүлэх замаар урьдчилан сэргийлнэ.*

### 1.1 Эрүүл мэндийн чиглэлээр

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоог бүрдүүлж Булган аймгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

- ✓ Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- ✓ Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.
- ✓ Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын мэдлэг, ур чадвар, тоног төхөөрөмжийн чанар хүртээмжийг дээшлүүлэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн үйлчилгээг дэмжин хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

- 
- ✓ Эрүүл мэндийн байгууллагын ажилтан ажиллагсдад зориулж орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
  - ✓ Орон нутаг, алслагдсан сумдын эмч, ажиллагсдыг байртай болгох, малжуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарал хандуулна.
  - ✓ Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ, чанар, хүртээмжийг сайжруулна.
  - ✓ Урьдчилан сэргийлэх эмчилгээ оношлогоог чанаржуулан эм, эм бэлдмэлийн хөтөлөлтийг сайжруулан иргэдийнхээ дундаж наслалтыг уртасгаж, хүн амын эрүүл мэндийг сайжруулна.
  - ✓ "Эрүүл шүд" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
  - ✓ Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудыг "Цахим эрүүл мэнд"-ийн хөтөлбөрт хамруулна.
  - ✓ *Àíðàí øàðíù ýìíýéýã, òíí àãàð ýàóóëüí íàðëéí ÿðäáýæëëéí ýí+ëéí ¿çëýã øëíæëëãýýã æëëãýý 2-íí ãíðã¿é óããà çìòëíí àãéãóóëæ* халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлж *ò¿í àíýý ÿð¿¿ëæ¿¿ëí*.
  - ✓ Эрүүл мэндийн байгууллага, хүн амыг чанарын баталгаатай эм, эмнэлэгийн хэрэгслээр тасралтгүй хангана.
  - ✓ Эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### 1.3 Нийтийн биеийн тамирын чиглэлээр

**Биеийн тамираар хичээллэх орчинг бүрдүүлэн идэвхитэй дасгал хөдөлгөөнийг амьдралын хэв маяг болгон хэвшүүлэхэд шаардагдах биеийн тамирын хэрэгсэл материалаар ханган, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.**

- ✓ Уламжлалт болон олимпын спортын төрлийг дэмжин, спортын мэргэжлийн холбоотой хамтран ажиллана.
- ✓ Аймаг, сумын төвүүдийн гудамж нийтийн эзэмшлийн талбайд стандартад нийцсэн спорт тоглоомын талбай, дугуйн зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг нэмэгдүүлнэ.
- ✓ Соёл амралтын паркыг өргөжүүлж, цана, тэшүүрийн спортын "Мөсөн гулгуур"-ын талбай байгуулан өвлийн спортыг дэмжин материаллаг бааз техник хэрэгслийн чанар хүртээмжийг сайжруулна.


### НОГООН ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭГЧ - БУЛГАНЧУУД

***Байгаль, орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглах экосистемийн тогтвортой байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлнэ.***

#### 1.1 Байгаль орчны чиглэлээр

**Хот суурин газрын ногоон байгууламжийн төлөвлөлтийг боловсронгуй болгож Ногоон хөгжлийн загвар аймаг болон хөгжүүлнэ.**

- ✓ "Ногоон хөгжил" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Байгаль орчинд ээлтэй төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Байгальд зохицсон ахуй соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, байгалийн нөөцийг ашиглах орчны бохирдол хаягдлыг багасгах байгальд халгүй техник технологийг нэвтрүүлнэ.
- ✓ Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.
- ✓ Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- ✓ Амьтан, ургамлын аймгийн байгалийн жамаар нөхөн сэргээх, тогтвортой ашиглах нөхцлийг бүрдүүлэн экосистемийн тогтвортой байдлыг ханган ажиллана.
- ✓ Ойн санг түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс хамгаалах, хууль бус мод бэлтгэх нөлөөллийг таслан зогсоох замаар ойн нөөцийг хомсдлоос сэргийлэх менежментийн чадавхийг сайжруулна.
- ✓ Айл өрх, албан байгууллагын хашаа, эзэмшил газар, нийтийн эзэмшлийн зам талбайг цэцэрлэгжүүлэх зүлэгжүүлэх ажлыг нийгмийн хариуцлагын хүрээнд сурталчилан таниулна.
- ✓ Ойн нөөцийг зохистой ашиглах, хяналт тавих, мод, модон бүтээгдэхүүнийг борлуулах "Ойн бирж"-ийг байгуулан байгаль орчинд ээлтэй дэвшилтэд техник технологийг нэвтрүүлнэ.
- ✓ Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцлийг бүрдүүлнэ.
- ✓ Тариалангийн үйлдвэрлэлийн хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургамлын өвчин, хортон шавьж, хог ургамал, мэрэгч амьтны тархалт, хор хөнөөлийн судалгаанд, тулгуурлан хөрс ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэн үүнд тавих хяналтыг тогтворжуулна.
- ✓ Орхон голын урсацын тохируулга хийх, усан сан байгуулах талаар судалгаа хийсний үндсэн дээр усны нөөцийн цогцолбор байгуулж усны нөөцийг хуримтлуулж ашиглана.



## 1.2 Аялал жуулчлалын чиглэлээр

**Аялал жуулчлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж дотоод гадаадын аялагчдад зориулсан аялалын маршрутыг сонирхол хэрэгцээнд нь тулгуурлан төрөлжүүлэн ногоон өв соёлыг хэвшүүлнэ.**

- ✓ "Аялал жуулчлалын дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж дотоод гадаадын аялагчдад зориулсан аялалын маршрутыг сонирхол хэрэгцээнд нь тулгуурлан төрөлжүүлэн тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- ✓ Диваажин, Цагаан суврага, Энергийн цэцэрлэгт хүрээлэнг холбосон шашин урлагийн цогцолбор төв босгон ашиглалтанд оруулан дотоод, гадаад жуулчдын нэгдсэн сүлжээнд оруулна.
- ✓

- ✓ Баяннуур Майхан уул “Шороон бумбагар”-ын хадгалалт, хамгаалалт, үзэсгэлэнгийн танхим, сан хөмрөг, сэргээн засах ажлыг эрчимжүүлж жуулчдын нэгдсэн сүлжээнд оруулна.
- ✓ Хатанбаатар Магсаржавын хөшөөт байгууламжийг барьж, соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнтэй замаар холбон иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчинг бүрдүүлнэ.
- ✓ Баян-Агт сумын Хануй, Цагаан гол, Хутаг-Өндөр сумын Их булаг болон Сайхан сумын Хунт нуур, Могод Хульжийн рашааны байгаль, экологийн судалгааг мэргэжлийн байгууллагаар судлуулах, байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх, тухайн орчинд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж, орчны бохирдлоос хамгаалан амрагч, жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ.
- ✓ Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж байгальд халгүй эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны баазуудын дэд бүтцийг шийдвэрлэж олон улсын жишигт хүргэнэ.
- ✓ Аялал жуулчлалын маршрутын дагуух соёлын өвийг сурталчлан таниулах замаар жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ.

### **НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛТАЙ – БУЛГАНЧУУД**

***Төрийн албаны ёс зүйг чанд мөрдүүлж, авилагаас ангид, ил тод нээлттэй байдлыг хангаж, төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг сайжруулна.***

#### **1.1 Төрийн үйлчилгээний чиглэлээр**

**Төр, засгийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.**

- ✓ "Цахим засаглал" хөтөлбөрийг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Орон нутгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, хяналт тавих хариуцлагатай, чадварлаг засаглалын бүтцийг бэхжүүлнэ.
- ✓ Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээний уялдааг хангах
- ✓ Нээлттэй, ухаалаг төрийн удирдлагын систем, нэгдсэн төвийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- ✓ Улс төрчид, төрийн албан хаагчдын ёс зүйн талаарх хууль тогтоомж, дүрмийг чанд мөрдүүлэн, бүх хэлбэрийн авилга, хээл хахуулийгустгана.
- ✓ Иргэний танхимаар иргэдийн суралцдаг, мэдээлдэг, зөвлөлддөг тогтолцоог улам боловсронгуй болгоно.
- ✓ Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж засаглалыг сайжруулан захиран зарцуулах санхүүгийн мэдээллийг ил тод болгоно.
- ✓ Татварын бааз суурийг өргөтгөх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд хүргэн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.

- ✓ Орон нутгийн төсвийн эх үүсвэрийг хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилан хэрэгжүүлэх, төсвийн ил тод байдлыг ханган ажиллана.
- ✓ Нягтлан бодох бүртгэл, аудит дотоод хяналтын тогтолцоог улсын жишигт нийцүүлэх, аж ахуйн нэгж байгууллагын бүртгэл хөтлөлт, тайлан гаргалтыг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, зарлагын хэмнэлтэд зэрэг нөлөө үзүүлэх, бүх шатны удирдлагад санхүү эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад арга зүйн туслалцаа үзүүлнэ.
- ✓ Санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд бүх талын зөвлөгөө дэмжлэг үзүүлнэ.
- ✓ “Ахмадын Хөгжлийн Төв” байгуулж, өдөр өнжүүлэх, зөвлөгөө өгөх, хөгжүүлэх үйлчилгээг өргөжүүлж, насжилтад бэлтгэж, ахмад настанд зориулсан үйлчилгээг шинэ шатанд гаргана.
- ✓ Гэр бүлийн үнэ цэнэ, эцэг эхийн хариуцлагын талаар залуу гэр бүлд мэдээлэл сургалт зөвлөгөө өгөх танхимыг төв болгон өргөжүүлэх
- ✓ Төрт ёсны уламжлалт, шинэчлэлийг хослуулж, төрийн албаны ёс зүй, хариуцлага, авилгагүй байх орчин нөхөрлөлийг бүрдүүлж ажиллана.
- ✓ Аялал жуучлал, түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн чиглэлээр Япон улстай хамтран ажиллана.

## 1.2 Гадаад харилцааны түншлэлийн хүрээнд

- ✓ Соёл, боловсрол, эрүүл мэнд, аялал жуучлалын чиглэлээр ОХУ, АНУ, БНСУ, БНХАУ-уудтай хамтран ажиллана.
- ✓ Хөдөө аж ахуйн чиглэлээр Беларусь, Турк улсуудтай хамтран ажиллана.
- ✓ Усжуулалтын систем байгуулж мод, жимс жимсгэнэ, малын тэжээл, төмс, хүнсний ногооны талбайг өргөжүүлэх талаар БНХАУ-тай хамтран ажиллах
- ✓ Булган аймгийн гадаад харилцаа эдийн засгийг хөгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-тай Бага Илэнхи-Айнекийн боомтын талаар хамтран ажиллана.
- ✓ Орон нутагт Евро стандартыг нутагшуулах байгууллага аж ахуйн нэгжүүдэд олон улсын стандартыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- ✓ Аялал жуулчлал, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн чиглэлээр Япон улстай хамтран ажиллана.

БУЛГАН АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ ЭНЭХҮҮ ХӨТӨЛБӨРӨӨ ХЭРЭГЖҮҮЛЖ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛТЭЙ  
“ШИНЭ БУЛГАН”-ЫГ, ОЛУУЛАА БҮТЭЭН БАЙГУУЛЦГААЯ

БУЛГАН НУТАГ МИНЬ МАНДАН БАДРАГ!!!



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.07.29 № 366  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

БАЯН-АГТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ БАЯН-АГТ СУМЫН АРДЧИЛСАН  
НАМЫН ДАРГА Л.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 – 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудитын MNS 6817 – 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим Төрийн аудит MNS 6817 – 8 : 2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Ардчилсан намын Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

006020565

Ардчилсан намын мөрийн хөтөлбөр / *К* хуудас/-ийг хавсаргав.  
Хувийг: Баян-Агт сумын Сонгуулийн хороонд  
Хавсралт *К* хуудастай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Шинэ* ДАНХБАЯР



БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2020 ОНЫ  
СУМЫН ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ “ШИНЭ БАЯН-АГТ”  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР



**АЖИЛТАЙ ОРЛОГОТой – БАЯН-АГТ**

*Хөдөө аж ахуйд суурилсан үйлдвэржилт, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.*

**1. Үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр**

**1.1 Үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр**

Орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий нэмүү өртөг шингээсэн, олон тулгуурт эдийн засгийг бий болгож, сумынхаа өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.

- ✓ “Нэг суурин - Нэг үйлдвэрлэл” хөдөлгөөнийг орон нутгийн онцлогт уламжлалт аргад тулгуурласан эцсийн бренд бүтээгдэхүүнийг боловсруулан зах зээлд нэвтрүүлнэ.
- ✓ Сумын ИТХ-аас орон нутгийн ААН байгууллагуудад газар олголтыг үе шаттай шийдвэрлэж зах зээлд өрсөлдөх чадвартай дэвшилтэт технологи бүхий үйлдвэр, цехүүдийг хөгжүүлнэ.
- ✓ Өөрийн сумын газар зүйн онцлог, байгалийн нөөц, дэд бүтцийн нөхцөл зэрэгт нийцүүлэн арьс шир, ноос ноолуур, өлөн гэдэс, сүү цагаан идээ, жимс жимсгэнэ, хүнсний ногоо зэрэг боловсруулах чиглэлийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- ✓ Сумдаа гурилын үйлдвэрийг тогтвортой үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэн сумынхаа гурилын дотоодын хэрэгцээг хангана.
- ✓ Түгээмэл тархацтай барилгын материалын түүхий эдийг боловсруулах, барилгын бетон хийц, тоосго зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- ✓ Сумын бодлогын бичиг баримтууд болон экосистемийн өнөөгийн нөхцөл, цаашдын хандлага, бэлчээр ашиглалт, хүн амын суурьшилтай уялдуулан газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.

**1.2 Худалдаа, үйлчилгээний чиглэлээр**

Сумын худалдаа үйлчилгээний салбарыг тэлэх бодлого баримтлан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

- ✓ Сумын ахуй үйлчилгээний төвийг үргэлжлүүлэн ажиллуулна.
- ✓ Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээг, бий болгоно.

- ✓ Орон нутгийн худалдаа үйлчилгээний газруудын чанар стандарт, хангалтыг дээшлүүлж хүн амыг олон нэр төрөл бүхий чанартай бараа бүтээгдэхүүнээр хангах, худалдааны зохистой хяналт хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ.
- ✓ Худалдаа, үйлчилгээний ажилтнуудын мэргэжлийн түвшинг дээшлүүлж, үйлчилгээний чанар стандарт, бараа бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулна.
- ✓ Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд тулгамдаж буй асуудлыг тэдгээрийн эрх ашгийг хамгаалдаг төрийн бус байгууллагуудаар дамжуулан сумын бодлого шийдвэрт тусгана.
- ✓ Худалдаа, үйлчилгээний салбарт ажиллаж буй аж ахуй нэгжүүдийг, зээл, хөрөнгө оруулалтын оновчтой бодлогоор дэмжинэ.

## 2. Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр

### 2.1 Газрын харилцаа барилга, хот байгуулалтын чиглэлээр

**Хүн амын нутагшилт суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт газрын харилцааг боловсронгуй болгоно.**

- ✓ "Сумын төвийн шинэчлэл төсөл"-ийг хэрэгжүүлж, сумыг төвлөрсөн дулаан цэвэр бохир, цэвэр усны нэгдсэн системийг өргөжлүүлнэ.
- ✓ Инженерийн шугам сүлжээний өргөтгөлийн ажлыг шат дараатайгаар шийдвэрлнэ.
- ✓ Шинэ суурьшлын бүсийг бий болгон инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй орон сууцыг шугам сүлжээнд холбож, нөхцөлийг бүрдүүлэх 10-аас доошгүй орон сууц барих
- ✓ Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд орон сууцны зориулалтаар тусгагдсан газруудад дэд бүтцийг байгуулах, орон сууц барих чиглэлээр хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.  
Орон нутгийг холбосон авто замыг түшиглэсэн түр амрах цэг бүхий амралтын цогцолбор газруудыг шинээр байгуулна.
- ✓ Сумын төв талбайн тохижилтыг үргэлжлүүлэн сайжруулж ногоон байгууламжийг нэмэгдүүлэн төв гудамжинд гоёлын ургамлаар бүрэн тарималжуулж нэрэмжит цэцэрлэгийг бий болгоно.
- ✓ Хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн ажиллаж хөдөлмөрлөх тавтай орчинг бүрдүүлнэ.
- ✓ "Сайн хашаа", "Жорлонгоо өөрчилье" зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

### 2.2 Тээвэр, автозамын чиглэлээр

**Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээвэр, автозамын чанар хүртээмжийг сайжруулна.**

- ✓ Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай зорчигч тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- ✓ Орон нутагт байгаа улсын болон орон нутгийн чанартай төмөр бетон гүүрнүүдэд их засвар хийх ажлыг зохион байгуулах,



### 2.3 Эрчим хүчний чиглэлээр

**Эрчим хүчний хэрэгцээг тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж нийт хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлнэ.**

- ✓ Эрчим хүчний хэрэгцээг тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж нийт хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний хувийг нэмэгдүүлж, баг сумын төв, хөдөөгийн малчин айл өрхийн гэрэлтүүлэг болон бусад хэрэглээг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангана.
- ✓ Нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг барилга байгууламжинд хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглана.
- ✓ Утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллахыг дэмжинэ.

### 2.4 Мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр

**Нийт хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамааран ижил хурдны үнэ тарифыг мөрдөж, сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалыг нэмэгдүүлнэ.**

- ✓ Сумын төв болон томоохон суурин газрууд, нийтийн эзэмшлийн талбай, олон нийтийн газарт интернэт холбогдох WIFI орчинг нэмэгдүүлнэ.
- ✓ Интернэтийн хурдыг сайжруулж, үнийг багасгаж хот хөдөөгийн эцсийн хэрэглэгчийг адил үнээр хамрагдахыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- ✓ Сумын нутаг дэвсгэр дээр байгаа аялал жуучлалын баазуудыг интернэтэд холбогдох нөхцлийг бүрдүүлж жуулчдын урсгалын нэмэгдүүлнэ.
- ✓ Хөдөөгийн алслагдсан багуудын үүрэн операторуудын сүлжээг сайжруулах, 3G сүлжээтэй болгох

## 3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байрны хэрэгцээг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэж, ажлын байрыг бий болгоход чиглэсэн боловсрол сургалтын үйл ажиллагааг дэмжиж албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг сайжруулан "Ажлын байр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.**

- ✓ Улс орнуудад "дадлагажигч ажилтан бэлтгэх" хөтөлбөрт иргэдээ оролцуулна.

- 
- ✓ Зохион байгуулалттай хөдөлмөр зуучийн үйлчилгээг дэмжиж, цалин, хөдөлмөрийн хөлсний уян хатан бодлого хэрэгжүүлж, цагийн ажлын байр, цагийн хөлсний системд шилжинэ.
  - ✓ Амьжиргааны түвшин доогуур иргэд болон бага малтай залуу малчин өрхийг дэмжиж малжуулах ажлыг үргэлжлүүлнэ.
  - ✓ Мах, сүү, гурил, хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого барьж орон нутгийн үйлдвэрлэгчдийг дэмжиж, дотоод зах зээлээ хамгаална.
  - ✓ Байгаль орчныг хамгаалах, нийтийн эзэмшлийн талбайг засах, тохижуулах зэрэг нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр хамруулна.
  - ✓ Хөдөлмөр зуучлалын нэгдсэн сүлжээг нэвтрүүлнэ.
  - ✓ Төр, ажил олгогч эздийн холбоо, үйлдвэрчний эвлэлийн 3 талт хамтын ажиллагааг өргөжүүлж сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодыг чадавхжуулна.
  - ✓ Оюутан залуучуудын холбоод болон ТББ-тай хамтарч залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
  - ✓ Сум хөгжүүлэх сангийн үр өгөөжийг дээшлүүлж, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
  - ✓ Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, барилгын ханын материалын үйлдвэрлэлийг түлхүү дэмжинэ.

#### 4. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр

Нийт мал сүргийн бүтцийг зохистой болгон, дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажсан өвчингүй статустай аймаг болгон, мал малын гаралтай бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргана.

- ✓ "Шинэ хөдөө" төслийг хэрэгжүүлнэ.
- ✓ "Чинээлэг малчин" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- ✓ Аймгийн төвд мал эмнэлгийн лаборатори, сумдад мал үржлийн нэгж, хувийн мал эмнэлгийн үйлчилгээг дэмжинэ.
- ✓ Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн үхрийг үндсэн сайжруулагчаар ашиглаж, ашиг шимийг нэмэгдүүлнэ.
- ✓ Хонин сүргийн үндсэн сайжруулагчаар Баяд үүлдэр, Дархад, Хотонт омгийг ашиглана.
- ✓ Ямаан сүргийн үндсэн сайжруулагчаар Эрчмийн хар, Баяндэлгэрийн улаан омгийг ашиглана.
- ✓ Малчид болон боловсруулах үйлдвэр хоорондын шууд харилцааг дэмжиж, МАА-н түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах оновчтой сүлжээг орон нутагт бий болгоно.

- ✓ Өвөлжөө хаваржааны бэлчээрийг, худаг уст цэгийн хамт малчдын бүлгүүдэд урт хугацааны гэрээгээр эзэмшүүлнэ.
- ✓ ХАА-н биржийн арилжааг идэвхижүүлнэ.
- ✓ Хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникын болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэн, хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлж элэгдэл, эвдрэлийг сааруулна.
- ✓ Үр тарианы үр үржүүлгийн аж ахуйг ганд тэсвэртэй, бүс нутгийн нөхцөлд тохирсон нутгийн үр сортыг бий болгож хэрэгцээг хангана.

## **АМГАЛАН ТАЙВАН – БАЯН-АГТ**

*Иргэн аж ахуйн нэгжийг болзошгүй гамшиг, гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах чадамжийг дээшлүүлэн амар амгалан ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.*

### **1.1 Батлан хамгаалах чиглэлээр**

Иргэн, цэргийн харилцааг бэхжүүлэх бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулж, аймгийн дайчилгааны хэрэгсэл нөхцлийг бүрдүүлэн, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий уялдаа холбоо хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

- ✓ Батлан хамгаалах туслах нийгэмлэг болон бусад байгууллагуудтай хамтран хүүхэд залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгоно.

### **1.2 Нийгмийн хэв журмын чиглэлээр**

Нийгмийн хэв журам сахиулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн иргэнд ээлтэй эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ.

- ✓ Шинэ суурьшлийн бүсүүдэд камержуулах, төв суурин газрын гудамж талбай, үйлчилгээний газруудын гэрэлтүүлэг, аюулгүй байдлын хяналтын сүлжээг сайжруулна.
- ✓ “Архигүй Баян-Агт” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж архи тамхины зөв зохистой хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.
- ✓ Малын хулгай, орон байрны хулгай, хориотой ан агнуур, хулгайн мод зэрэгтэй тэмцэнэ.
- ✓ Гэрч хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг дэмжин ажиллана.

### **1.3 Онцгой байдлын чиглэлээр**

Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан оудлах, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, улсын хэмжээнд болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэл, эмзэг байдал, хохирлыг бууруулах олон нийтэд тулгуурласан менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, гамшигтай тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ.



- ✓ Болзошгүй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, сайн дурын бүлэг, иргэдийн идэвхи санаачилгыг дэмжинэ.
- ✓ Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулж гамшгаас хамгаалах болон удирдах бүрэлдэхүүний сургууль, дадлага хийх
- ✓ Онцгой нөхцөлд шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулж гар багаж зэвсэглэмжийг нэмэгдүүлэх

#### 1.4 Хүн ам зүйн бодлого

Хүнсний аюулгүй байдлыг хангах, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, иргэдийн тоог тогтмол нэмэгдүүлж хүн амыг амьдрах ая тухтай орчинг бүрдүүлнэ.

- ✓ Хүнсний аюулгүй байдлыг цогцоор нь хангах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж сургалтын давтамж, хүртээмж, үр дүнг сайжруулна.
- ✓ Хүн амыг амьдрах аятай тухтай орчныг бүрдүүлэн нийгмийн халамж үйлчилгээг сайжруулан хүн амыг тогтвортой өсгөнө.
- ✓ Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагчдын тоог нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж баталгааг хангана.
- ✓ Хүнийг хөгжүүлэх, хүний нөөцийг бүрэн дүүрэн ашиглах замаар хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг улсын дундаж түвшинд хүргэнэ.
- ✓ Нийгмийн халамжийн зорилтод бүлгүүдэд чиглүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, ахмад настан, эмэгтэйчүүдэд үзүүлдэг тусламж, хөнгөлөлтийг сайжруулах замаар дэмжлэг үзүүлэн ажиллана.
- ✓ Жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана.
- ✓ Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын тоог суурин хүн амын 90 хувьд хүргэнэ.
- ✓ Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн зорилтод бүлгүүдэд хандсан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан дэмжлэг тусалцааг нэмэгдүүлнэ.

#### ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ – БАЯН-АГТ

